

“ХААН СОЁМБО АУДИТ”- ХХК



САНХҮҮГИЙН ХУРААНГУЙ ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2025/053/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
2025 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Ичинхорлоо
Утас: 88012671 Цахим хаяг: ichinkhorlooga@audit.gov.mn

Хаан соёмбо аудит ХХК-ын захирал: Х.Диймаа
Утас: 99065668 Цахим хаяг: info@khaansoyomboaudit.mn

Гүйцэтгэсэн аудитор: Н.Ган-эрдэнэ
Утас: 88115349 Цахим хаяг: gannerdene108@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvs gul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 1/224
танай _____ -ны № _____ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЭРДЭНЭБУЛГАН
СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧИЙН ҮҮРЭГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ М.АЛТАНТУЯА ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд 19,909.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн ажилтанд олгосон урамшуулал, хөрөнгөтэй холбоотой 42,862.2 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 5 зөвлөмжийг хүргүүлж ажилласан.

Бусад асуудлын хэсэг

Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч нь 2024 онд аймгийн Боловсролын газрын даргатай гэрээ байгуулан ажиллаж, хэрэгжилтийг 83.6 хувийн гүйцэтгэлтэй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

67212188

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>266,343,822.54</u>	<u>312,332,195.25</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	92,465,845.66	107,104,219.65
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	92,465,845.66	107,104,219.65
3121	Төгрөг	92,465,845.66	107,104,219.65
31211	Төрийн сангийн харилцах	92,465,845.66	107,104,219.65
35	БАРАА МАТЕРИАЛ	173,770,489.60	205,227,975.60
351	Түүхий эд материал	3,308,033.00	6,069,800.00
35130	Эм боох материал	3,308,033.00	6,069,800.00
354	Хангамжийн материал	170,462,456.60	199,158,175.60
35410	Бичиг хэргийн материал	7,378,847.00	5,496,036.00
35420	Аж ахуйн материал	42,343,140.50	42,994,269.50
35440	Түлш, шатах тослох материал	16,420,000.50	20,785,000.50
35450	Барилгын засварын материал	11,399,320.00	10,686,070.00
35460	Хүнсний материал	13,120,686.00	8,418,887.00
35470	Бусад хангамжийн материал	79,800,462.60	110,777,912.60
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>671,593,542.98</u>	<u>673,101,957.14</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	671,593,542.98	673,101,957.14
392	Биет хөрөнгө	657,114,142.98	658,721,557.14
39201	Барилга, байгууламж, орон сууц	639,024,700.00	639,024,700.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-68,373,907.80	-82,048,689.44
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	98,561,312.08	109,971,157.08
39206	Хуримтлагдсан элэгдэл	-45,012,915.67	-45,012,915.67
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	24,551,663.30	33,051,663.30
39208	Хуримтлагдсан элэгдэл	-16,453,918.99	-18,737,502.47
39214	Бусад үндсэн хөрөнгө	61,309,360.00	61,309,360.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-39,556,833.64	-41,900,899.36
39217	Ном	3,064,683.70	3,064,683.70
393	Биет бус хөрөнгө	14,479,400.00	14,380,400.00
39301	Програм хангамж	1,012,000.00	1,012,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,012,000.00	-1,012,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	14,479,400.00	14,479,400.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-99,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>937,937,365.52</u>	<u>985,434,152.39</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>937,937,365.52</u>	<u>985,434,152.39</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	937,937,365.52	985,434,152.39
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	168,390,133.00	168,390,133.00
51101	Өмч: - төрийн	168,390,133.00	168,390,133.00
512	Хуримтлагдсан үр дүн	753,025,132.52	800,521,919.39
51210	Өмнөх үеийн үр дүн	753,025,132.52	753,025,132.52
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	47,496,786.87
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	16,522,100.00	16,522,100.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>937,937,365.52</u>	<u>985,434,152.39</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	772,040,210.00	1,010,433,645.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	47,441,610.00	19,909,845.00
120	Нийтлэг татварын бус орлого	47,441,610.00	19,909,845.00
	Төсөвт байгууллагын өөрийн орлого	35,000.00	5,000,000.0
	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Үндсэн хөрөнгө	47,110,610.00	19,909,845.00
	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Бараа материал	296,000.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	724,598,600.00	985,523,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	690,598,600.00	940,023,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	690,598,600.00	940,023,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	34,000,000.00	45,500,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	34,000,000.00	50,500,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	636,321,466.28	962,936,858.13
21	УРСГАЛ ЗАРДАЛ	636,321,466.28	962,936,858.13
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	636,315,116.50	937,134,519.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	445,783,696.34	708,463,714.69
210101	Үндсэн цалин	295,509,504.12	475,413,944.29
210102	Нэмэгдэл	136,197,098.22	212,929,402.40
210104	Урамшуулал	14,077,094.00	20,120,368.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,086,800.00	91,549,300.00
210201	Тэтгэврийн даатгал	38,819,100.00	59,822,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,566,900.00	9,754,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,653,600.00	3,662,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	913,300.00	3,662,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,133,900.00	14,647,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,269,450.22	10,332,661.54
210301	Гэрэл, цахилгаан	5,248,650.22	5,697,661.54
210302	Түлш, халаалт	6,520,800.00	3,135,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,500,000.00	1,500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,957,129.00	15,394,532.00
210401	Бичиг хэрэг	3,128,600.00	6,342,931.00
210402	Тээвэр, шатахуун	4,764,629.00	5,127,501.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,813,900.00	3,924,100.00
2105	Нормативт зардал	69,036,656.00	75,840,130.60
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	451,250.00	480,733.00
210502	Хоол, хүнс	68,585,406.00	75,359,397.60
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,041,450.00	9,660,850.00
210604	Урсгал засвар	7,041,450.00	9,660,850.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	00.00	495,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	495,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	34,139,934.94	25,398,330.84
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,945,200.00	6,996,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	28,194,734.94	18,401,430.84
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,349.78	25,802,338.46
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6,349.78	25,802,338.46
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,349.78	25,802,338.46
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	135,718,743.72	47,496,786.87
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	135,718,743.72	47,496,786.87

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	168,390,133.00	16,522,100.00	615,017,857.86	799,930,090.86
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	168,390,133.00	16,522,100.00	615,017,857.86	799,930,090.86
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-3,680,140.13	-3,680,140.13
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	168,390,133.00	16,522,100.00	753,025,132.52	937,937,365.52
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	168,390,133.00	16,522,100.00	753,025,132.52	937,937,365.52
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	168,390,133.00	16,522,100.00	753,025,132.52	937,937,365.52
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	47,496,786.87	47,496,786.87
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	168,390,133.00	16,522,100.00	800,521,919.39	985,434,152.39

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	724,633,600.00	990,523,800.00
	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	35,000.00	5,000,000.00
	Нийтлэг татварын бус орлого	35,000.00	5,000,000.00
	Төсөвт байгууллагын өөрийн орлого	35,000.00	5,000,000.00
	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,000.00	5,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	724,598,600.00	985,523,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	690,598,600.00	940,023,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	690,598,600.00	940,023,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	34,000,000.00	45,500,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	34,000,000.00	50,500,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	628,264,378.34	972,049,081.01
21	УРСГАЛ ЗАРДАЛ	628,264,378.34	972,049,081.01
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	628,258,028.56	946,246,742.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	445,783,696.34	708,356,227.41
210101	Үндсэн цалин	295,509,504.12	475,306,457.01
210102	Нэмэгдэл	136,197,098.22	212,929,402.40
210104	Урамшуулал	14,077,094.00	20,120,368.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,086,800.00	91,549,300.00
210201	Тэтгэврийн даатгал	38,819,100.00	62,253,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,566,900.00	7,323,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,653,600.00	3,662,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	913,300.00	3,662,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,133,900.00	14,647,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,993,650.22	14,697,661.54

Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210301	Гэрэл, цахилгаан	5,248,650.22	5,697,661.54
210302	Түлш, халаалт	17,245,000.00	7,500,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,500,000.00	1,500,000.00
2105	Нормативт зардал	72,252,882.00	69,097,598.60
210502	Хоол, хүнс	72,252,882.00	69,097,598.60
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,000,000.00	10,000,000.00
210604	Урсгал засвар	10,000,000.00	10,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	990,000.00	2,545,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	990,000.00	2,545,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,151,000.00	50,000,155.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,918,200.00	42,933,855.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,232,800.00	7,066,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,349.78	25,802,338.46
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6,349.78	25,802,338.46
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,349.78	25,802,338.46
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	96,369,221.66	18,474,718.99
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	3,836,345.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	3,836,345.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	3,836,345.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	3,836,345.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-3,836,345.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	96,369,221.66	14,638,373.99
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	387,524.00	92,465,845.66
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	92,465,845.66	107,104,219.65

2.5 Аудит хийсэн улсын төсвийн гүйцэтгэлийн тайлан

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	92,465,845.66		-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,032,454,600.00	925,385,426.01	107,069,173.99	89.6
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	1,032,454,600.00	925,385,426.01	107,069,173.99	89.6
210	Бараа, үйлчилгээний зардал	1,032,454,600.00	925,385,426.01	107,069,173.99	89.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	807,674,300.00	708,356,227.41	99,318,072.59	87.7
210101	Үндсэн цалин	548,060,100.00	475,306,457.01	72,753,642.99	86.7
210102	Нэмэгдэл	252,846,000.00	212,929,402.40	39,916,597.60	84.2
210104	Урамшуулал	6,768,200.00	20,120,368.00	-13,352,168.00	297.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	94,575,300.00	91,549,300.00	3,026,000.00	96.8
210201	Тэтгэврийн даатгал	64,312,700.00	62,253,500.00	2,059,200.00	96.8
210202	Тэтгэмжийн даатгал	7,564,400.00	7,323,900.00	240,500.00	96.8

Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210203	ҮОМШӨ ний даатгал	3,783,000.00	3,662,000.00	121,000.00	96.8
210204	Ажилгүйдлийн даатгал	3,783,000.00	3,662,000.00	121,000.00	96.8
210205	Эрүүл мэндийн даатгал	15,132,200.00	14,647,900.00	484,300.00	96.8
2105	Нормативт зардал	71,392,900.00	69,097,598.60	2,295,301.40	96.8
210502	Хоол, хүнс	71,392,900.00	69,097,598.60	2,295,301.40	96.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	2,545,800.00	2,545,800.00	0.00	100.0
210806	Мэдээллийн технологийн зардал	2,545,800.00	2,545,800.00	0.00	100.0
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	56,266,300.00	53,836,500.00	2,429,800.00	95.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	49,200,000.00	46,770,200.00	2,429,800.00	95.1
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,066,300.00	7,066,300.00	0.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,032,454,600.00	940,023,800.00		
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	940,023,800.00	940,023,800.00	0.00	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	940,023,800.00	940,023,800.00	0.00	100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	92,430,800.00	-	92,430,800.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	92,465,845.66		-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	107,104,219.65		-
	БАЙГУУЛЛАГЫН ТОО				
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	30.0	30.0		100.0
62001	Удирдах ажилтан	1.0	1.0		100.0
62002	Гүйцэтгэх ажилтан	19.0	19.0		100.0
62003	Үйлчлэх ажилтан	10.0	10.0		100.0

Орон нутгийн төсвийн гүйцэтгэл:

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
	ХӨТӨЛБӨР 71801	-	-	-	-
	АРГА ХЭМЖЭЭ 80111	-	-	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	45,500,000.00	24,697,661.54	20,802,338.46	54.3
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	45,500,000.00	24,697,661.54	20,802,338.46	54.3
210	Бараа, үйлчилгээний зардал	45,500,000.00	24,697,661.54	20,802,338.46	54.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,500,000.00	14,697,661.54	25,802,338.46	36.3
210301	Гэрэл цахилгаан	8,500,000.00	5,697,661.54	2,802,338.46	67.0
210302	Түлш, халаалт	30,500,000.00	7,500,000.00	23,000,000.00	24.6
210303	Цэвэр, бохир ус	1,500,000.00	1,500,000.00	-	100
2106	Эд хогшил худалдан авах	5,000,000.00	10,000,000.00	-5,000,000.00	200
210604	Урсгал засвар	5,000,000.00	10,000,000.00	-5,000,000.00	200
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	45,500,000.00	24,697,661.54	20,802,338.46	54.3
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	38,000,000.00	24,697,661.54	20,802,338.46	54.3
132001	Орон нутгийн төсвөөс	38,000,000.00	24,697,661.54	20,802,338.46	54.3
	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	7,500,000.00	5,000,000.00		
	Туслах үйл ажиллагааны орлого		5,000,000.00		

	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	7,500,000.00			
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	31	30	-	100
620001	Удирдах ажилтан	1	1	-	100
620002	Гүйцэтгэх ажилтан	19	19	-	100
620003	Үйлчлэх ажилтан	11	10	-	100

5. Аудитын илрүүлэлт

Аудитаар төсвийн зарцуулалт, худалдан авах ажиллагаа, хөрөнгөтэй холбоотой 42,862.2 мянган төгрөгийн 5 зөрчил илрүүлж 5 зөвлөмж хүргүүлсэн.

5.1 Аудитын залруулга

Аудитаар нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой залруулга хийгээгүй болно.

5.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

5.3 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөөгүй болно.

5.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой

Илрүүлэлт:

Тус цэцэрлэгийн эрхлэгчийн 2024 оны 07 сарын 23-ны өдрийн А/28 тушаалаар байгууллагын нягтлан бодох бүртгэлийн ажилтанд 1,042.5 мянган төгрөгийн урамшууллыг олгохдоо ажлын үр бүтээлийг үнэлсэн хангалттай баримтыг үндэслээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т заасныг зөрчсөн ба эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудыг урамшуулахдаа ажлын үр дүнг бодитой тооцож, улирлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулахгүй байхад анхаарч ажиллах

2. Хөрөнгийн данстай холбоотой

Илрүүлэлт:

Тайлант онд үндсэн хөрөнгийн шинж чанартай 33,620.2 мянган төгрөгийн хөрөнгийг бараа материал дансанд бүртгэсэн байна. Энэ нь Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 10.1.Үндсэн хөрөнгө нь бараа, үйлчилгээний үйлдвэрлэл буюу нийлүүлэлтэд ашиглах, бусдад түрээслүүлэх, эсхүл удирдлагын хэрэгцээнд ашиглах зорилгоор эзэмшиж байгаа бөгөөд нэгээс дээш жилээр ашиглагдах биет хөрөнгө юм” гэж заасантай нийцээгүй ба санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгийг 2025 оны эхний хагас жилд багтаан бараа материал данснаас хасч үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж, элэгдэл тооцох

Илрүүлэлт:

2024 оны хичээлийн шинэ жилд сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байгаа хүүхдийн хичээлийн хэрэгслэл, сургалтын болон эрүүл ахуйн хэрэгслэлийн хандивт эцэг эх, асран хамгаалагч нараас өгсөн 8,200.0 мянган төгрөгийн хичээлийн хэрэглэгдэхүүнийг орлогоор бүртгэж, санхүүгийн тайланд тусгаагүй байна. Энэ нь Боловсролын ерөнхий газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 24-ны өдрийн а/243 дугаар тушаал, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.5-д “бүх орлого” гэсэн заалтуудтай нийцэхгүй ба санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Хүүхдүүдийн эцэг эхээс авсан сургалтын хэрэглэгдэхүүнийг 2025 оны эхний хагас жилд багтаан бараа материал дансанд орлого авч бүртгэлд тусгах.

3. Худалдан авах ажиллагаатай холбоотой

Илрүүлэлт:

Тус цэцэрлэг 2024 онд байгууллагын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд бараа, ажил үйлчилгээ худалдан авахаар 13 компанитай байгуулсан гэрээний үр дүнг дүгнээгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.7-д “худалдан авах гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавих, удирдлагаар хангах, хэрэгжилтийг цахим системд хөтлөх”, мөн хуулийн 48.2.9-д “энэ хуулийн 54.6-д заасан гүйцэтгэгчийн үүргийн гүйцэтгэлийг баталгаажуулах, мэдээллийн үнэн зөвийг хариуцах” гэсэн заалтуудтай нийцэхгүй ба ба санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Гэрээ байгуулсан байгууллагуудтай гэрээний үр дүнг дүгнэж, акт протокол үйлдэж хэвших.

3.Ахмадын тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой

Илрүүлэлт:

Тус байгууллага нь Ахмадын тухай хуулийн холбогдох заалтын дагуу ахмадын сан байгуулж, жилийн төсөвтөө төлөвлөж батлуулаагүй байна. Энэ нь Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 "Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална", Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-тай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Ахмадын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, хууль журмын дагуу байгууллагын төсвийн төсөлдөө ахмадын санг төлөвлөн батлуулж ажиллах

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг аудитын тайлан хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор гаргаж, fas.audit.mn системд оруулж, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 09 дүгээр сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/Мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Урамшуулал олгох шийдвэр гаргахдаа ажлын үр дүнг бодит байдал нийцүүлэн үнэлээгүй зөрчил илэрсэн.	1	1,042.0					1	1,042.0
Үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг бараа материал дансанд бүртгэсэн	1	33,620.2					1	33,620.2
Хүүхдүүдийн эцэг эхээс авсан сургалтын хэрэглэгдэхүүнийг орлого авч бүртгэлд тусгаагүй	1	8,200.0					1	8,200.0
Дүн	3	42,862.2					3	42,862.2

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ахмадын тухай хуулийн дагуу ахмадын сан байгуулж ажиллаагүй.	1	0					1	0
Гэрээ байгуулсан байгууллагуудтай гэрээний үр дүнг дүгнээгүй	1	0					1	0
Дүн	2	0					2	0
Нийт дүн	5	42,862.2					5	42,862.2